

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2003 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

Мэргэжлийн байгууллагаас тогтоосон
үйлчилгээний зарим хураамжийн
хэмжээг бууруулах тухай

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.12 дахь заалтыг үндэслэн Үнэт цаасны хорооноос ТОГТООХ НЬ:

1. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг биржийн арилжааны бус хэлцлээр худалдсан тохиолдолд өмчлөх эрхийг шилжүүлэхдээ тухайн үнэт цаасыг худалдан авсан болон худалдсан тал тус бүрээс авах үйлчилгээний хураамжийг үнийн дүнгийн 5 хувиас хэтрүүлэхгүйгээр тогтоосугай.

2. “Хөрөнгийн бирж” ХК-д гишүүнээр элсэх анхны хураамжийг 3.0 сая төгрөг, суудлын эрх авах гишүүний хураамжийг 8.0 сая төгрөгнөөс хэтрүүлэхгүйгээр тус тус тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хорооны 1998 оны 41 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Хорооноос тогтоосон хураамжийн хэмжээг холбогдох журамд тусгуулан мөрдөн ажиллахыг “Хөрөнгийн бирж” ХК, “ҮЦГТТХТ” ХХК-ийн удирдлагад тус тус даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ